**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 29 өдөр Дугаар А/521 Арвайхээр

Ургамлын нөмрөгийн судалгааг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.б дахь заалт, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, бэлчээрийн хүрэлцээ, даацыг тодорхойлох зорилгоор жил бүр сум, багийн түвшинд ургамлын нөмрөгийн судалгааг шинэчлэн тогтоох ажлын хэсгийг хавсралтаар баталж, судалгаанд шаардагдах шатахууны зардлыг гаргаж, 2019 оны 08 дугаар сарын 20-ны дотор судалгааны дүнг сумынхаа хэмжээнд нэгтгэн аймгийн Засаг даргын дэргэдэх Ус цаг уур орчны шинжилгэний албанд ирүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Сум, багийн түвшинд хийсэн ургамлын нөмрөгийн судалгаа болон цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурлан өвөл, хаврын улирлын бэлчээрийн даацад тохируулан малын тоог бууруулах, цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх ажлын талаар сумын удирдлагуудад зөвлөмж хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга (Б.Оюунчимэг) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ГАНБОЛД

01110091

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2019..... оны ..07.
дугаар сарын ..29..ны өдрийн ..А/521. дугаар
захирамжийн хавсралт

УРГАМЛЫН НӨМРӨГИЙН СУДАЛГААГ ТОГТООХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч- Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: -Сумын Хөдөө аж ахуйн тасгийн мал аж ахуйн үйлдэрлэлийн технологи, малын үржил, бүртгэл, бэлчээрийн менежмент хариуцсан мэргэжилтэн
Сумын Байгаль орчны улсын байцаагч
Сумын Газрын даамал
Сумын Цаг уурын ажилтан
Багийн Засаг дарга нар

--oOo--